

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

**ТЕЛЕВИЗИЙН АЯЛЛЫН НЭВТРҮҮЛГИЙН
ХӨТЛӨГЧИЙН УР ЧАДВАРЫН АСУУДАЛД**

Б.Наранбаатар*, У.Мандаа**

* МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант, магистр (МА)

Түлхүүр үг: аяллын нэвтрүүлэг, телевизийн сэтгүүл зүй, хөтлөгчийн ур чадвар, байр суурь, хүмүүжил боловсрол, олон нийтийн соёл

Аяллын нэвтрүүлгийн нэр төрөл олширсон өнөө үед, дэлхийн олон улс оронд аяллын нэвтрүүлгийн хөтлөгч нар ч олон тодорч гарчээ. Хөтлөгч бол телевизийн аяллын нэвтрүүлгийн гол дүр бөгөөд хөтлөгчийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь аяллын нэвтрүүлэг урт хугацаанд оршин тогтнох, хөгжихөд түлхэц болох юм.

Монгол Улсын хэл судлаач эрдэмтэн Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар” номдоо нэвтрүүлэгч гэдэг үгийг нэвтрүүлэг хийх үүрэгтэй хүн. Радио нэвтрүүлэгч, суртал нэвтрүүлэгч гэж бий хэмээн тайлбарласан байна. Харин хөтлөгч гэдэг үгийг ямар нэгэн зүйлийг хөтөлдөг хүн гэж тайлбарлажээ. Уг тольд нэвтрүүлэх гэдэг үгийг тараан дэлгэрүүлэх, хөтлөх гэдэг үгийг юмнаас барьж дагуулан явах, удирдан жолоодох гэжээ. Оросын судлаач С.И.Ожегов “Орос хэлний тайлбар толь” номдоо диктор-нэвтрүүлэгч бол микрофоны өмнө эх бичвэр уншдаг

радио, телевизийн ажилтан, харин ведущий-хөтлөгч гэдэг үгийг ямар нэгэн зүйлийг удирдах үүрэгтэй оролцдог хүн хэмээн тайл-барласан байна. Эндээс радио, телевизийн нийтлэл нэвтрүүлгийг олон түмэнд хүргэхээр тараан дэлгэрүүлэгч нь нэвтрүүлэгч, харин сонсогч үзэгчдийг удирдан залж дагуулагч нь хөтлөгч хэмээн ойлгож болохоор байна.

Өвөр Монголын судлаач Шилингуа “Телевизийн хөтлөгчийн дүр төрхийн тухай өгүүлэх нь” хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэлдээ “Үзэгчид нэвтрүүлгийг сонирхохдоо хамгийн түрүүнд хөтлөгчийн дүр төрхийг анзаардаг бөгөөд үүний дараагаар нэвтрүүлгийн бодит агуулгыг хүлээн авдаг болохоор эрдэмтдийн хөтлөгчийн талаарх судалгаа олширч тэдний хэл яриа, хувцаслалт, үйл хөдлөл, барил, тайзыг эзэгнэх чадвар, аливааг сэргэгээр хүлээн авах чадамж, хэв боловсрол, гоёл засал зэргийг олон талаас ажиглан судалж байна”¹ хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Хөтлөгчийн дүр төрх бол бол хувь хүний дүр төрх, зуучлуурын дүр төрх (нэвтрүүлгийн дүр төрх), үзэгчдийн үнэлэлт, зэргийг багтаадаг. Түүний амжилт олох

эсэх нь гурван элементээс шалтгаална. Нэгд, хөтлөгчийн **хувь хүний дүр төрх** ба энэ нь суурь болох элемент, дараа нь **нэвтрүүлгийн дүр төрхийн тухай хувь хүний ойлголт**, энэ нь зангилгын элемент, хамгийн сүүлд **үзэгчдийн биеч төрөгдөл**, энэ нь хөтлөгчийн дүр төрхийг үнэлэх баримжаа болдог. Хөтлөгчийн хувь хүний дүр төрх нь нэвтрүүлгийн дүр төрхтэй нийцэх тутам үзэгчдийн таашаал хүртэнэ. Хөтлөгчийн хувь хүний дүр төрх, нэвтрүүлгийн дүр төрх ба үзэгчдийн үнэлэлт хандлагын хоорондын харьцаа нь хөтлөгчийн дүр төрхийг бүтээх чиглэл ба нэвтрүүлгийн рейтингийг тогтооход нөлөөлнө².

БНХАУ-д нэвтрүүлгийн хөтлөгчийг тав хувааж үздэг. Эдгээр нь нэгдүгээрт, сонин мэдээ, шүүмжийн нэвтрүүлгийн хөтлөгч, хоёрдугаарт, утга зохиол, урлаг, цэнгээнт нэвтрүүлгийн хөтлөгч, гуравдугаарт, сурган хүмүүжил, үйлчилгээний нэвтрүүлгийн хөтлөгч, дөрөвдүгээрт, спортын нэвтрүүлгийн хөтлөгч, тавдугаарт, хүүхдийн нэвтрүүлгийн хөтлөгч юм.

Аяллын нэвтрүүлгийн хөтлөгч нь утга урлаг, цэнгээнт нэвтрүүлэг болон сурган хүмүүжил үйлчилгээний нэвтрүүлгийн хөтлөгчид тавигддаг хэв шинжийн аль алийг нь хавсарч илэрхийлдэг.

БНХАУ-д утга урлаг, цэнгээнт нэвтрүүлгийн хөтлөгч нь дээд боловсролтой, мэдлэгийн цар хүрээ өргөнтэй, хөгжимдөж тоглох авьяастай, зөв дүр төрхтэй, дууны өнгө сонсголонтой, 19-45 насны хүн хөтөлж болох бөгөөд баримжаа авиагаар оновчтой, амьдлаг илтгэдэг, эмэгтэй хөтлөгч бол нэн сайн гэж үздэг. Нэвтрүүлгийг хөтлөх үедээ чөлөөтэй, цовоо сэргэлэн, элгэмсүү, инээд бялхам бөгөөд нүүрний хувиралт олон, хэл ам хурц байхыг илүүд үздэг

байна. Мөн үзэгчидтэй үзэл бодлоо халуун дотноор хуваалцахыг эрхэмлэдэг³.

Харин сурган хүмүүжил, үйлчилгээний нэвтрүүлгийн хөтлөгчид тавигдах шаардлага нь гэвэл дээд боловсролтой, мэдлэгийн цар хүрээ өргөнтэй, аль нэг мэргэжлийг гаргуун эзэмшсэн, ямар ч насны хүн хөтөлж болох бөгөөд гадаад хэл мэддэг, оновчтой үг хэллэг ашиглаж чаддаг, баримжаа авиагаар ярьдаг байх хэрэгтэй гэж дурдсан байдаг. Гадаад дүр төрхийн талаар онцгой шаардлага тавьдаггүй боловч нэвтрүүлгийг чөлөөтэй хөтөлж, үзэгчидтэй санал бодол санаагаа солилцох хэрэгтэй гэж үздэг байна⁴.

Хятад, Монголын аяллын нэвтрүүлгийн хөгжлийн явцаас олж харахад аяллын нэвтрүүлгийн дэлгэрснээс, хөтлөх арга хэлбэр янз янзын олон хөтлөгч гарч ирлээ. Аяллын хөтөч, хэвлэл мэдээлэл хэрэгслийн төлөөлөгч болсны хувьд, өөрийн уг мэргэжлийн шинж чанарт шинэ шаардлага танилттай болжээ. Иймээс, зөвөөр аяллын нэвтрүүлгийг ойлгож, зөвөөр аялал жуулчлалын нэвтрүүлгийн хөтлөгчийн ур чадварыг хүмүүжүүлэх нь улс орныхоо аялал жуулчлал нэвтрүүлгийн эрүүл ба түргэн хөгжихөд түлхэц болно.

Аяллын нэвтрүүлгийн хөтлөгч нь дээр дурдсан шинжүүдийн аль алийг нь хамарч болно. Ингээд аяллын нэвтрүүлгийн хөтлөгчийн үндсэн боловсрол, шинж чанарыг дэлгэрэнгүй авч үзье.

Өнөөгийн шинжлэх ухаан технологи хурдацтай хөгжин, телевизийн нэвтрүүлгийн төрөл зүйл олширч, аяллын нэвтрүүлгийн үүссэн нь, сонин мэдээ, олон ангит кино, уран сайхан, цэнгээнт нэвтрүүлэгтэй хамт оршиж, дэлгэцийн агуулгыг хуваалцаж байх нь,

мөн аяллын нэвтрүүлгийн хөтлөгч улмаар нэмэгдэж байгаа гэснийг харуулж байна. Хөтлөгч аяллын нэвтрүүлэг дотор их ач үйлдлийг үзүүлдэг, нэвтрүүлгийн агуулгаас шалтгаалж, хөтлөгчид тавигдах шаардлага бас өндөр байдаг, аяллын нэвтрүүлгийн онцгой шинж болон аялал жуулчлал хийж байгаа тухайн газрын ерөнхий мэдлэг нь, хөтлөгчийн ерөнхий боловсрол мэргэжилд маш өндөр шаардлагатай юм. Иймээс мэргэжлийн хүмүүжил нь хөтлөгчийн ур чадвар ба хувь хүмүүний хүмүүжил боловсролтой уялдуулах хэрэгтэй. Аяллын нэвтрүүлгийн хөтлөгчид хувь хүнийхээ үүднээс анхаарч төлөвшүүлбэл зохистой дараах мэдлэг, чадварыг нэн чухал хэмээн онцолж байна.

- Ёс суртахууны хэв боловсрол. Нэгэн амжилттай хөтлөгч болъё гэвэл, эрхбиш хүн болж сурах хэрэгтэй гэдэг үг бол хөтлөгч бүрийн заавал бүрдүүлэх ёс суртахууны хүмүүжил боловсрол юм. Аяллын нэвтрүүлгийн хөтлөгч болоход ажил үйлсч сэтгэл ба хариуцлагатай байх хэрэгтэй. Хөтлөгч олон өнцгөөс асуудлыг харж, таньж мэдэх, тайлбарлах, түүнчлэн зөв оновчтойгоор үзэгчдийг удирдаж, аяллын мэдлэгийг ойлгуулж мэдүүлэх хэрэгтэй.
- Соёл боловсрол. Аяллын нэвтрүүлгийн хөтлөгч нь соёлын суурь мэдлэгээ өргөжүүлж, ажлын туршлагаа сайн хуримтлуулсан суурин дээр, цаашдаа, аяллын нэвтрүүлээ урт удаан хугацаагаар хөтөлж чадна.
 - Өндөр түвшинд мэргэшин, өргөн цар хүрээний мэдлэгтэй байх. Мэдлэгийн түвшний хэр хэмжээ бол нэг хөтлөгчийн соёл боловсролыг хэмжих чухал зарчим юм. Өнөөгийн олон хөтлөгчийн хувьд

гоё сайхан дүр дүрс ба мэдлэгийн хэмжээ бүрдсэн. Гэвч тэнд өөрийн сурч шингээсэн мэдлэгийн чадвараа ажил дээрээ хэрэгжүүлж чадахгүй, харин тухайн үед нь сурч, тухайн үед нь хэрэглэж, гол сэдвээсээ салж гардаг. Мэдлэгийн түвшний сайн муу байх нь практик үйл ажиллагааны явцад илэрдэг. Гүн гүнзгий аялал жуулчлалын мэдлэг байвал сая үзэгчдийг зөвөөр замчилж, нэвтрүүлгийн танилцуулга дундаа алдаа гаргаж, үзэгчдийн шүүмжлэлд өртөхгүй.

- Практик, туршлагадаа үндэслэн өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх. Түмэн газар аялж, түмэн ном унших, мэдлэг болон практик нь диалектик нэгдлийн харьцаа юм. Аяллын нэвтрүүлгийн цэнгээний элемент нь амьдралаас үүдэлтэй, баялаг амьдралын практик нь, нэвтрүүлгийн хөтлөгчийн шинийг үүсгэн бүтээх чадвар ба хөгжлийн суурь, практикийн дундаас туршлага хуримтлуулж, хүчрийн дундаас дахин боловсорно.
- Хөтлөх ур чадвартаа байнга анхаарах. Аялал жуулчлал нэвтрүүлгийн хөтлөгч бол чөлөөт аяллын төлөөлөгч, нэвтрүүлгийн гол хүчин тулгуур. Аяллын сайн нэвтрүүлэг нь хөтлөгчийг амжилтад хүргэдэг. Сайн хөтлөгч олон түмнийг баясгаж явдаг. Нэг хошин үг энгийн хүний амнаас гарвал хүмүүсийн чихэнд сонсогдоод, хүмүүс нэг л инээгээд өнгөрнө. Харин адилхан хошин үгийг хөтлөгчийн амаас сонсвол илүү олон хүний сэтгэлд хоногшин үлдэнэ. Жишээлбэл, Хятадын төв телевизээр 2019

оны гуравдугаар сарын 13-нд үзүүлсэн “Алсын алс дахь нутаг” (远方的家) нэвтрүүлгийн хөтлөгч Хү Шин нь хээр гадаа орчны үзэмжийг тайлбарлахдаа өөрийн гэсэн өвөрмөц арга барилтай байсан нь үзэгчдийн сэтгэлд сайн хүрсэн.

- Шинэлэг сэтгэлгээтэй байх. Тайзан дээр нэг минут, тайзан доор арван жилийн чармайлт, хичээл зүтгэл гэх оноч үг бий. Аяллын нэвтрүүлгийн хөтлөгч болсны хувьд, мэргэн оюун ухаантай, эрдэм мэдлэг ихтэй ба хөтлөх ур мэргэжил байхаар барахгүй, бас заавал амьдралыг мэдрэх, амьдралыг ойлгох, үзэгч нэвтрүүлгээс юуг хүсэж байгааг ойлгох хэрэгтэй.

Үүнээс үүдэн аяллын нэвтрүүлгийн хөтлөгчийн байр суурийг илэрхийлэх дор дурдах хэдэн зүйлийг чухалчилж үзэх хэрэгтэй.

Нэгдүгээрт, аяллын нэвтрүүлэг дунд, хөтлөгчийг үг яриа үйл ажиллагаанаас нэвтрүүлгийн зорилгыг шууд тусгаж чаддаг, нэвтрүүлэг хөтлөгчийг амжилтад хүргэдэг. Хөтлөгч бол нэвтрүүлгийн замчлагч. Аяллын нэвтрүүлгийн хөтлөгч, үзэгчдэд дэлхийн аливаа газар, улс орны өнгө үзэмж ба ёс заншлыг танилцуулахын дагууд, мөн өөр соёлыг хүмүүст харуулж, чөлөөт аяллыг замчилсан түүчээ болно.

Хоёрдугаарт, олонх телевиз ашиг ба алдагдлаа өөрөө хариуцах хэлбэр маягаар оршдог. Телевизийн хүлээн авч үзэх норм ба ашиг орлого нэмэгдүүлэхийн хамгийн чухал байранд тавьж, аяллын нэвтрүүлгийн хөтлөгч, нэвтрүүлэг төсөвлөх болон шинэчлэх ажиллагаанд оролцохдоо олон талаас хязгаарлагдмал болсон. Том ашиг нөлөөллийн хандлагаар нэвтрүүлэг

үйлдэж хийж байгаа хүмүүс, хөтлөгчийн шинэчлэх чадвар ба бүтээлч чадварыг үл хайхарч, зөвхөн хөтлөгчийн нүүрэн талын цэнгээн хөгжөөх чадварыг чухалчилж, дотоод хүмүүжил боловсролыг хөнгөвчилж, хөтлөгчийн нэвтрүүлэг дэх хэрэгцээ ба удирдамжийн үйлдлийг бодолхийлсэнгүй, сохроор ашиг хонжворыг хөөцөлдөх нь элбэг. Нэвтрүүлгийн амин сүнс болсны хувьд, хөтлөгч өөрсдийнхөө гадаад дүр төрхийг анхаарахын зэрэгцээ өөрсдийн дотоод хүмүүжил боловсролыг бас дээшлүүлэх хэрэгтэй байна.

Аяллын нэвтрүүлгийн хөтлөгчийн мэргэжлийн ур чадварыг төлөвшүүлэхэд доорх дөрвөн зүйлийг анхаарч хүмүүжүүлэх хэрэгтэй.

- Суралцах хүсэл, тэмүүлэлтэй хөтлөгчийг төлөвшүүлж, өргөн цар хүрээний мэдлэгтэй хүн болгох. Ололт ялалтын хойно мэдлэгийн тунадас хэрэгтэй, аяллын нэвтрүүлгийн хөтлөгч эрхбиш олон төрлийн мэдлэг эзэмших хэрэгтэй байна. Жишээлбэл, одон орон, газар зүй, дэлхийн түүх, аливаа газар орны ёс заншил, идээ, ургамал, амьтан зэрэг юм болгоныг мэдрэхийн тухай хүмүүжүүлэх нь нэг хоёр өдөрт зааж сургачихдаг биш, тайзан дээр нэг минут, тайзан доор арван жилийн бэлтгэл гэх мэт суралцах дуртай хөтлөгчийг хүмүүжүүлэхэд, зөвхөн явцуу утгаар нь ном бичиг дээрээс сурах биш, харин амьдрал дунд асуудлыг илрүүлж, судалж, шийдвэрлэж эцэст нь мэдлэг хуримтлуулна.
- Өвөрмөц хэв маяг, стилийг төлөвшүүлж, шинэчлэх санааг нэмэгдүүлж, адилшлаас зайлсхийнэ. Аялал жуулчлалын нэвтрүүлгийн хөтлөгч нь нэвтрүүлгийн амин судас юм. Өвөрмөц зангүй,

онцлоггүй хөтлөгч нэвтрүүлгийн гол тулгуур хүчин болж чадахгүй, зарим улс орны аяллын нэвтрүүлгийн хэлбэр маяг нь хэвшмэл, хүн болгон дуурайн хийж, иймэрхүү орчинд, хэрвээ хөтлөгч өөрийн онцлог шинж байхгүй, хөтлөх арга маяг нь нэгэн хэвийн, уйтгартай бол нэвтрүүлэг нь ч үзэгчдийн сонирхлыг татаж чадахгүй. Өөрийн гэсэн хөтлөх стилийг бий болгон, өөрийн өвөрмөц хэв маягаа илрүүлэх нь, хөтлөгч болсны хувьд заавал байх мэргэжлийн хүмүүжил боловсрол болно. Нэгэнт нэвтрүүлгийн хөтлөгч болсны хувьд, өөрийн шинэчлэх ухамсрыг хүмүүжүүлж, уг байсан нэвтрүүлгийн суурин дээр өөрчлөлт хийж, нэвтрүүлгийн хөтлөгчийн хөтлөх стиль нь адилавар болохоос зайлсхийнэ.

- Зугаа цэнгэлээр хүмүүжүүлэх үзэл ухамсрыг бий болгож, нэвтрүүлгийн агуулгыг баяжуулж, болхи бүдүүлэг агуулгаас зайлсхийнэ. Нэвтрүүлгийн агуулга нь улмаас улам зугаа цэнгээнээр болж олшрохын нөлөөлөл доор, аялал жуулчлалын хөгжлийн үүрэг нь хүнд байдаг. Аяллын нэвтрүүлэгт оршиж байгаа асуудал нь мэргэжлийн хүрээнд хүмүүсийн анхаарлыг ихээр татаж байгаа, олонх аяллын нэвтрүүлгийн хөтлөгч үг чалчих, тоглоом шоглоом хийх үзэгдэл энд тэнд илэрч байна. Ихэнх нэвтрүүлэг болхи бүдүүлэг үзэгдэл зүг хандаж, онц урьсан зочдоо элэглэж дооглох үзэгдэл бас зөндөө гарч, олон залуучууд багачуудад нэлээд муу нөлөө өгдөг. Аяллын нэвтрүүлгийн хөтлөгч болсны хувьд цэнгэл баяр хөөрөөр хүмүүжүүлэх үзэл ухамсрыг бий болгож, худал, хий хоосон байж болохгүй. Нэвтрүүлгийн наадам тоглоом явагдах үед хөтлөгч

хэтрүүлж болохгүй, аяллын нэвтрүүлэг нь хоосон хүмүүсийг инээлгэж тоглуулах биш, харин цэнгээн дунд хүмүүжүүлэх зорилготой юм.

- Бүх талаар сонирхож чадах боловсролтой аялал жуулчлал нэвтрүүлгийн хөтлөгч болох. Аяллын нэвтрүүлгийн хөтлөгч болсны хувьд, өөрийн дотоод хүмүүжил боловсролоо чангатгаж, сайн муу бүх талыг сонирхож чадах боловсролтой хөтлөгч болж, үг яриан дээрээ оновчтой, үйл хөдөлгөөн нь уяхан, хошин шогийн мэдрэмжтэй, ярьсан үгний утга ойлгомжтой, үзэгчидтэйгээ хамт баясан, хүмүүсийн оюун ухааныг эерэг зүгт удирдаж, иймэрхүү үзэл ухамсартай болбол бүх талаар сонирхож, өндөр хүмүүжил боловсролтой хөтлөгч болж чадна. Нэвтрүүлгийн хөтлөгч бол телевиз, хэвлэл мэдээллийн дүр бүтээгч, мөн чөлөөт аяллын удирдагч. Асар түргэн хөгжсөн эл улс оронд, хэвлэл мэдээллийн салбар нь хөгжин дэлгэрч, нэвтрүүлгийн төрөл зүйл олширч, үзэгчид нэвтрүүлэгт хандах шаардлага ч өдрөөс өдөр өндөр болсон байна. Аяллын нэвтрүүлгийн хөтлөгчийн хүмүүжил боловсрол нь нэвтрүүлгийг улам сайжруулах болно.

Ишлэл

- ¹ Шилингуа. Телевизийн хөтлөгчийн дүр төрхийн тухай өгүүлэх нь. МУИС-ийн “Сэтгүүл зүй” ЭШБ. УБ., 2014. №15 (417). х.86.
- ² Хуан Юу Мин, Жан Жуо. Хөтлөгчийн дүр төрхийг бүтээх. Хуа Жун Шинжлэх Ухаан Техник Мэргэжлийн Их Сургуулийн хэвлэлийн хороо.2006. х.9.
- ³ Ху ЮнФан. Ван ШиЖиэн. Телевизийн нэвтрүүлгийн хөтлөгчийн ажил мэргэжлийн ур чадварыг үнэлэх үзүүлэлтийн тогтолцооны судалгааны үр

бүтээлийн эмхэтгэл. Дундад Улсын Радио Телевиз Хэвлэлийн хороо. 1999. х.7-8.

⁴ Мөн тэнд.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Шилингуа. 2014.(15). Телевизийн хөтлөгчийн дүр төрхийн тухай өгүүлэх нь. МУИС-ийн “Сэтгүүл зүй” ЭШБ. УБ.
2. Хуан Юу Мин, Жан Жуо. 2006. Хөтлөгчийн дүр төрхийг бүтээх. БНХАУ-Үү Хан.
3. Ху ЮнФан. Ван ШиЖиэн. 1999. Телевизийн нэвтрүүлгийн хөтлөгчийн ажил мэргэжлийн ур чадварыг үнэлэх үзүүлэлтийн тогтолцооны судалгааны үр бүтээлийн эмхэтгэл. БНХАУ-Бээжин.
4. Шү Же. 2015. Телевиз нэвтрүүлгийн хөтлөгчийн ажил мэргэжилийн ур

чадварын тухай өгүүлэх нь. БНХАУ-Ши Ан.

5. Баяртогтох М. 2016. Сэтгүүлч-хөтлөгчөөр мэргэших оюутан, сонирхогчдын бие дааж суралцах хялбарчилсан гарын авлага. УБ.

Резюме

Авторы данной статьи затрагивают вопрос о квалификации ведущих телевизионных программ, в частности телепередач о путешествиях. В статье уделяется основное внимание тому, какие знания, навыки и способности должен приобрести ведущий телепрограммы о путешествиях. Также авторы приводят примеры развития тревэл-журналистики в разных странах на фоне информационных технологий.